



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г

ТУЗ-ын дүгнэлт батлах тухай

Т

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 96.5 дахь заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.47.11 дэх заалт, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 03 тоот тогтоол, 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д. ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Үйл ажиллагааны тайлан,
ногдол ашгийн тайлан
батлах тухай

Т

Компанийн тухай хуулийн 96.4, 46.15 дахь заалт, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоол, Техник импорт ХК-ийн 2023 оны 04-р сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. 2022 оны компанийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайланг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Ногдол ашиг хуваарилах тухай 7
ТУЗ-ын шийдвэрийг батлах тухай

МУ-ын Компанийн тухай хуулийн 46.1 дэхь заалт, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02-р сарын 15-ны өдрийн 02 тоот тогтоол, 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Техник импорт ХК-ийн ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ын шийдвэрийг баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 2000 төгрөгийн ногдол ашиг олгосугай.
3. Компанийн ногдол ашгийг 2023 оны 04-р сарын 14-ний өдрөөс эхлэн компани дээрээс олгосугай.
4. Тогтоосон хугацаанд аваагүй Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-д байрлах дансанд байршуулахаар шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэгт зөвшөөрсүгэй.
5. Компанийн Хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу ногдол ашиг олгохыг Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэг, Бизнес хөгжил, санхүү хариуцсан захирал С.Дашдулам нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г Үйл ажиллагааны төлөвлөгөө 7
батлах тухай

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоол, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. 2023 оны компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралтын дагуу баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г Компанийн бүтэц, зохион байгуулалтыг Г
батлах тухай

Компанийн тухай хуулийн 96.4 дэх заалт, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоол, Техник импорт ХК-ийн 2023 оны 04-р сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн бүтэц, зохион байгуулалтыг Хавсралтын дагуу баталсугай.
2. Хавсралтын дагуу компанийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэгт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА




Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.11.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоол, 2023 оны 04-р сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дараахь нэр бүхий хүмүүсийг 2023 оны Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр сонгосугай.

ТУЗ-ын ердийн гишүүд:

1. Т.Тунгалаг ✓
2. Д.Баяраа ✓
3. С.Бүжинлхам ✓
4. Г.Уран-Өлзий ✓
5. Л.Уртнасан ✓
6. Э.Батболд ✓

ТУЗ-ын хараат бус гишүүд:

1. Ж.Баярсайхан ✓
2. Б.Батсайхан ✓
3. Б.Нарантуяа ✓

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 1 жилийн хугацаатай сонгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдэлж компанийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Г ТУЗ-ын дэргэдэх хороодыг Г
байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дах заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.62 дах заалт, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйл, 2023 оны 04-р сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороог тус тус байгуулсугай.
2. Хороо тус бүрийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

А. Аудитын хорооны дарга Гишүүд	Ж.Баярсайхан Б.Батсайхан Д.Баяраа
Б. Нэр дэвшүүлэх хорооны дарга Гишүүд	Б. Нарантуяа Б.Батсайхан Г.Уран-Өлзий
В. Цалин, урамшууллын хорооны дарга Гишүүд	Б.Батсайхан Ж.Баярсайхан Т.Тунгалаг

1. Техник импорт ХК-ийн Дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасан эрх, үүргийн хүрээнд холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Г Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 7
зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.11.13 дахь заалт, 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны хурлын 01 тоот дүгнэлт, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг Хавсралтын дагуу баталсугай.
2. Хавсралтаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо /Т.Тунгалаг/-нд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Г 7
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.8, 69.1 дэхь хэсэг, Компанийн “Дүрэм”-ийн 7.26 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ирцийн дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 1429550 хувьцаа эзэмшдэг 8 хувьцаа эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 1 446 755 ширхэг энгийн хувьцааны 98,8 хувь болж байгааг Хурлын дарга, Хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсэг, Компанийн “Дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.26 дахь хэсгийг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 98,8%-ийг эзэмшигчид хуралд оролцож байгаа тул 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Д. ПҮРЭВСҮРЭН



**ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

Хурлын хэлэлцэх асуудлаар санал хураахад:


1. Нийт саналын хуудас 8 хуудас
Саналын хүчинтэй хуудас 8 хуудас
Саналын хүчингүй хуудас 0 хуудас тус тус тоологдов.
2. Санал хураалтын дүн:

д/д	Санал өгөхөөр хэлэлцсэн асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт	+		
2.	2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан	+		
3.	2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө	+		
4.	2023 оны компанийн бүтэц, зохион байгуулалт	+		
5.	2023 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	+		

Жич: "Зөвшөөрсөн" "Татгалзсан" "Түдгэлзсэн" аль нь болохыг (+) тэмдгээр илэрхийлнэ.
Нэг мөрөнд зөвхөн нэг тэмдэглэгээг хийнэ.

3. Компанийн "Дүрэм"-ийн 7.13 дахь заалтын дагуу дийлэнх олонхийн саналаар:
 - 3.1. 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
 - 3.2. 2022 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
 - 3.3. 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
 - 3.4. 2023 оны компанийн бүтэц, зохион байгуулалт
 - 3.5. 2023 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай тогтоолуудыг тус тус батлав.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА
ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН



Д.ПҮРЭВСҮРЭН
Д.МӨНХТУЯА